

Н.Нандин-Эрдэнэ^{1✉}, Э.Амарболд¹

¹ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Богтаг малтайн нэгэн цог чимгийн тухай

Товчлол. Энэхүү өгүүлэлд Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж буй, 1980 онд археологич Д.Наваан, Х.Лхагвасүрэн нарын судалгааны багийнхан Дархан уул аймгийн Хонгор сумын нутагт орших Буурал уулын 2-р булшинд хийсэн археологийн малтлага судалгаагаар олдсон дундад зууны үед хамаарагдах нэгэн цог чимгийн тухай өгүүлэх болно. Бид тухайн олдворыг судалгааны эргэлтэд оруулахыг зорьж байгаа юм.

Түлхүүр үг: Цог чимэг, богтаг малгай, чандмань хэлбэр, Буурал уул, дундад зууны үе

N.Nandin-Erdene^{1✉}, E.Amarbold¹

¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences, Building-1, Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Decorations of the Bogtag Headdress

Summary. We will discuss decorations on a Mongolian wife hat. Two decorations were found in the second burial at Buural Mountain in Khongor sum, Darkhan Uul province in 1980. They are stored in the Funds of Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences. In total, there are two fragments.

The first decoration is well-preserved and round in shape. The chemical analyses of the first artefact show that it is made of silver and gold. On it, there are two other metal decorations in the shape of a sun and a moon, which demonstrates the link to the Xiongnu and Mongol Empire totem, ritual, and ancestry.

The second decoration was found in a broken state, with half of the piece being lost. We were able to reconstruct the piece to get a complete decoration pattern, which was determined to be a “Chandmani” pattern. The artefact comprises a small piece of organic textile and stone. We analyzed the textile under a microscope and found that the textile was made using a weaving method called a “yorog”.

Keywords: Tsog decoration, bogtag wife's hat, chandman type, Buural mountain, medieval period

Удиртгал

Нүүдэлчин монголчуудын хувцас хэрэглэлд малгайг чухалд тооцож, тухайн хүний нас, хүйс, зэрэг дэв, бэл бэнчин зэргийг тодорхойлдог нэгэн зүйл хэмээн үздэг. Эртний монгол эмэгтэйчүүдийн дүр төрхийг онцлон тодотгодог зүйл бол монгол эхнэрийн “Богтаг” хэмээх малгай билээ [Ангарагсүрэн, Мөнхцэцэг 2020: 152]. Богтаг нь толгойд тавих буюу өмсөх хэсэг дээшээ өргөссөн хэлбэртэй оройн хэсэг хоёрыг холбох хуйлмал нарийн үйсэн хоолой гэсэн гурван хэсгээс бүрдэнэ [Эрдэнэбат 2010: 9]. Үүнийгээ даавуу болон торгоор өнгөлж богтаг малгайнхаа урд цохон дээр үнэт эрдэнийн чулуун шигтгээтэй алтан мөнгөн чимэглэл хаддаг байсан. Малгайн их бага, чимэг зүүсгэлд хэрэглэсэн материал эзнийхээ хөрөнгө чинээ, зэрэг зиндааг илтгэдэг [Эрдэнэбат 2010: 18]. Богтаг малгайн энэхүү өвөрмөц чимэглэлийг монголчууд “цог” гэж нэрлэж байсныг “Монголын Нууц Товчоон”-ны 115-р зүйлд тэмдэглэсэн байдаг [Эрдэнэбат, Төрбат 2011: 28]. Монгол эхнэрийн богтаг малгайг бусдаасаа ялгаруулах ганц зүйл нь цог чимэг юм. Монгол хэлэнд “Цог” хэмээх үг нь цог жавхлантай, сүр хүчтэй, галтай цогтой зэрэг утгыг илтгэдэг байна. XIII-XIV зууны Монгол баян чинээлэг язгууртан эхнэрүүд богтаг малгайндаа үнэт эрдэнийн чулуун шигтгээтэй ийм алтан мөнгөн чимэглэл хадаж байсан нь Юань улсын монгол хатдын хөргөөс тодорхой мэдэгдэх бөгөөд Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгойн 5-р булшнаас олдсонтой яг адил хийц хэлбэртэй, алтан утсан сүлжмэлээр урлаж хийсэн эрдэнийн шигтгээтэй богтагны чимэглэл [Эрдэнэбат 2010: 14] Монгол улсын Архангай аймгийн Хулхийн амны 8-р булш [Эрдэнэбат 2010: 14], Сүхбаатар аймгийн Асгат сумын Шарга уулын 2-р булш [Эрдэнэбат 2010: 14], БНХАУ-ын Өвөр Монголын Аохань хошуу [Эрдэнэбат 2010: 15], БНХАУ-ын Өвөр монголын Шилийн гол аймгийн Зүүн Үзэмчин Бухар орчмын Шахриябын баянбүрдээс олдсон [Эрдэнэбат 2010: 15], ОХУ-ын Санкт-Петербург хот дахь Эрмитаж музейд хадгалагдаж байгаа эдгээр чимэглэлээс харж болно [Эрдэнэбат 2010: 15].

Ордон юм уу, ихсийн дэргэд тусгай гар урчууд байсныг батлах нэгэн баримт одоо Өвөр Монголын Алшаа аймгийн нутагт буй, 1227 онд Чингисийн хааны байлдан эзэлсэн Тангудын нийслэл болох Хар хотоос олжээ. Тэр нь урлангийн газарт хувцас захиалж даалгасан данс байна. Уг данс нь ууж дээл, богтаг малгай, гутал зэргийг бүрэн чимэгтэйгээр хийж үйлдэхийг даалгасан утгатай байжээ. Үүнээс харахад ихэс дээдсийн охид харьд одох, хүнтэй суухад иж бүрэн хувцаслах, эрэлхгээр тулалдаж гавьяа байгуулсан баатар эрсэд иж бүрэн хуяг дуулга, зэр зэвсэг бэлэглэх

зэрэгт зориулсан урлангийн газартай байжээ [Эрдэнэбат 2010: 15].

Буурал уулын 2-р булшнаас илэрсэн чандмань хэлбэрийн цог чимэгтэй адил чимгүүд Зүчийн улсын үеийн Ставрополь мужийн Киевское тосгоны ойролцоо Юн-Бабагийн толгод, Селитрэнни сууринаас санамсаргүй байдлаар илэрч олджээ [Крамаровский 2019: 144].

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй, боловсруулалт

Дархан уул аймгийн Хонгор сумын төвөөс 3 км зайтай Хараа голын зүүн хойд тал Буурал уулын зүүн энгэрт энэхүү дурсгалт газар оршино. Тус газарт Монгол-Зөвлөлтийн түүх-соёлын хамтарсан экспедиц, Түүхийн хүрээлэнгийн Сэлэнгэ, Булганы археологийн хайгуул шинжилгээний анги [Наваан 1980-82: 109] 1980-1984 оны хооронд малтлага судалгаа хийж 20 гаруй булш малтан судалсан байна. Үүнээс 2-р булш нь 1-р булшнаас зүүн урагш 5 м-т орших бөгөөд зууван дугуй хэлбэртэй. Энэхүү булшны эзэн нь 25-30 орчим насны эмэгтэй хүн байсан бөгөөд оршуулга 1 м-ийн гүнээс илэрч олджээ [Эрдэнэбат 2009: 243]. Илэрч олдсон эд өлгийн зүйлсийн дотор богтаг малгайд бэхэлсэн гурван өөр металл бүхий чимэглэл илэрч олдсон нь бидний судалгааны хэрэглэгдэхүүн болох цог чимэглэл юм.

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгийн бүртгэн баримтжуулах, хадгалалт хамгаалалтын сайжруулалтын ажлын явцад 1980 онд археологич Д.Наваан, Х.Лхагвасүрэн нарын Дархан уул аймгийн Хонгор сумын нутаг Буурал уулын 2-р булшнаас олж илрүүлсэн богтаг малгайн чимэглэлүүдийн тухай энэхүү судалгаандаа өгүүлнэ. Эдгээр чимэглэлийн мэдээллийг хайсан боловч тухайн олдворуудын талаар судлаачид тайландаа цухас дурдсанаас өөрөөр шинжлэх ухааны эргэлтэд оруулаагүй даруй 40 гаруй жилийг өнгөрөөсөн байна. Иймд бид тус олдворын ерөнхий тодорхойлолтыг бичих, анхны төрх байдлын онцлог шинжийг тодруулах, хэлбэр хийцийг зургаар сэргээх, сурвалжийн мэдээтэй харьцуулах, судалгааны эргэлтэд оруулахыг зорилоо.

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн “Булш оршуулгын сан хөмрөг”-ийн туслах бүртгэлд БУ-83 дугаартай хадгалагдаж байна.

Бид энэхүү судалгаагаар илэрч олдсон богтаг малгайн дугуй мөнгөн чимэглэлтийг цаашид товчлон 1-р чимэглэл, Чандмань хэлбэрийн чимэглэлийг 2-р чимэглэл хэмээн нэрлэнэ. Энэхүү судалгаандаа гэрлийн микроскопын арга болон химийн найрлага тогтоох шинжилгээг ашигласан.

1-р чимэглэл. Энэхүү чимэглэл нь дугуй хэлбэртэй, 1.3 см голчтой, 0.1 см зузаантай. Нүүр болон ар талдаа ижил хээ, дүрсэн чимэглэлтэй. Тодруулбал, хагас дугуй дүрсийг 4 тийш харуулан хонхойлгон дүрсэлсэн. Дээд талын хагас дугуй дүрс дээр дугуй дүрсийг мөн хонхойлгон дүрсэлсэн байна. Энэ нь нар, сарыг төлөөлүүлэн дүрсэлсэн бололтой. (Зураг 1). Үүний дээр ар талдаа хадаж тогтоож байсан органик эдлэлийн үлдэгдэлтэй. Тухайн зүйлийг нарийн утсаар зүйж тогтоож байсан нь хадгалагдан үлдсэн байна.

2-р чимэглэл. Буурал уулын 2-р булшнаас чандмань хэлбэрийн өөр нэгэн чимэглэл илэрсэн. Уг чимэглэлийн тал хэсэг нь үрэгдэж алга болсон тул бид анхны байдлыг зургаар сэргээн чандмань хэлбэрийн зохиомжийг тодруулахыг оролдсон юм. Нимгэн хавтгай хүрлийг чандмань хэлбэрт оруулан цутгаж дусал болон дугуй хүрээтэй нуухыг их биеэс товойлгон урлаж органик болон тана эрдэнийг шигтгэн чимэглэжээ. Чимэглэлийн хэмжээ ойролцоогоор 4.7 см өндөртэй, 5 см өргөнтэй, 0.2 см зузаантай. Мөн гол чимэглэлд нийлэхгүй чимэглэлийн хэсэг байгаа тул тусад нь оруулсан юм. Магадгүй гол чимэглэлийн үрэгдэж алга болсон хэсэгтэй нийлж чандмань хэлбэрийг үүсгэж байсан болов уу хэмээн бид таамаглаж байна. Тус чимэглэл нь 3.1 x 2.2 см хэмжээтэй, тана эрдэнийг шигтгэж байсан ул мөр үлдсэн байна (Зураг 2).

Материалын судалгаа

1-р чимэглэл. Энэхүү одон гарагийн тэмдэг дүрсэлсэн чимэглэлийг ямар төрлийн металлээр хийснийг Соёлын өвийн үндэсний төвийн Сэргээн засварлах газрын мэргэжилтэн X-Ray буюу Рентген флуоресценцийн (X-Ray fluorescence) багажийг ашиглан химийн найрлагын шинжилгээг бидэнд хийж өгсөн. Шинжилгээгээр мөнгө (Ag) 96.11%, төмөр (Fe) 1.81%, зэс (Cu) 0.75%, алт (Au) 0.72%-ийг эзэлж байна. Судалгааны үр дүнд мөнгөн эдлэл болохыг тодорхойлсон бөгөөд мөн алтны орц бага зэрэг байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Буурал уулын 2-р булшнаас илэрч олдсон богтаг малгайн 1-р чимэглэл болох дугуй мөнгөн чимэглэлийн ард хадгалагдаж үлдсэн органик эдлэл нь магадгүй хусны үйс болон бөс даавууны үлдэгдэл бололтой. Бид гэрлийн микроскопын ашиглан зургийг авсан юм (Зураг 5,6).

Монгол эхнэрийн богтаг малгайг хийх үндсэн материал нь хусны үйс байдаг. Хусны үйсээр малгайнхаа хэлбэрийг гаргаад гадна талаар нь бөс даавуу, торгоор бүрж дээр нь элдэв гоёл чимэглэлээ хатгадаг байсан талаар тухайн үеийн сурвалж бичгүүдэд тодорхой тэмдэглэсэн байдаг.

2-р чимэглэл. Тус чимэглэлийн үндсэн эх

биеийг хүрэл болон зэсээр хийсэн бололтой. Чимэглэлийн шигтгээнд нь органик гаралтай зүйл болон “Тана” чулуу орсон байсныг бид дээр өгүүлсэн билээ. Үүнээс сонирхол татахуйц нэгэн зүйл ажиглагдаж байгаа нь чимэглэлийн оройн шигтгээг органик зүйлээр чимжээ. Иймд тухайн шигтгээнд ямар материал орсныг мэдэх зорилгоор гэрлийн микроскопын ашиглан үзэхэд энгийн ёрог нэхээстэй бөс даавуу болох нь тодорхой болсон юм (Зураг 3,4). Энгийн ёрог нэхээс гэдэг нь бүтцийн хувьд хамгийн энгийн нэхээс бөгөөд бусад төрлийн нэхээснүүдийн суурь нь болдог юм. Энэ нэхээсний техник нь босоо болон хөндлөн чиглэлдээ ижил буюу утаснуудыг хооронд нь нэг босоо утас, нэг хөндлөн утас гэсэн харьцаагаар харилцан солбиулах зарчмаар нэхдэг. Уг нэхээсийг хамгийн эртний нэхээсний төрөл [Мүраками 2020: 116] гэж үздэг. Гэвч бид мэргэжлийн түвшинд материал болон ширхэглэлийн судалгааг хийгээгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй болов уу (Зураг 7,8).

Чимэглэлүүдийн хээ, дүрс утга бэлгэдэл


1-р чимэглэл. Ар болон өвөр талдаа “☀” нар, сарны дүрстэй ажээ. Нар, сар хоёр бол очирт хөлгөний Бурхны шашны хамгийн чухал од гарагийн тэмдэг болдог. Алтан улаан нар билиг чанарын оюун билгийг төлөөлдөг бол мөнгөн цагаан сар арга чанарын мэргэн арга, нигүүлсэхүй сэтгэлийг төлөөлнө. Нар сарны дүрсээр ээмэг сүйх, толгойн засал, энгэрийн чимэг, барьц багаж хийж болох ба Цогт охин тэнгэр, Балданлхам зэрэг сахиуснуудын хүйсээс дүрэлзэн ноцсон нар сацраад, орчихуйн далайг ширгээж, төгс төгөлдөр болохын “нахиа”-г боловсруулж байгааг бэлгэднэ. Шинэдийн сарыг Шиватай хамаа бүхий ядам бурхан, Чакрамсамвара, Будда-гавал, Цогт цагийн хүрдэн зэргийн орой дээр зурдаг. Энэ сар энэрэл нигүүлсэнгүй сэтгэл, бодь сэтгэлийн цагаан дусал нэмэгдэж байгаа, бурхдын ухаарлын хүч улмаар нэмэгдэж байгааг бэлгэднэ хэмээн үздэг байна [Бийр 2022: 100-101].

Нүүдэлчдийн анхны эзэнт гүрэн Хүннүгийн соёлд нар, сарны шүтлэг, бэлгэдэл маш тодорхой ул мөр үлдээсэн [Баярсайхан 2021: 8]. Нар, сарны дүрсийн утга бэлгэдлийг ихэнх судлаачид Сыма Цяны “Түүхэн тэмдэглэл” бүтээлд дурдсан “Шаньюй өглөөд өргөөнөөсөө гарч мандах наранд мөргөл үйлдэнэ. Оройд саранд мөргөнө... Дайн хийхдээ сар болон од эрхсийн байрлалыг ажиглана. Бүтэн сартайд давшина, сар хагаслахад (цэргээ) эргүүлж татна...”[Сыма Цяны 2014: 48] хэмээх мэдээнд тулгуурлан Хүннүгийн язгууртнууд нар, сарыг хэрхэн эрхэмлэн дээдэлж шүтэж байсны хөдөлшгүй баримт юм. Хүннүгийн дараа Монгол нутагт мандаж, буурч явсан Сяньби, Жужан, Түрэг,

Химийн найрлагын хүснэгт

Ag%	Fe%	Cu%	Au%	Pb%	Ti%	Sn%	In%	Mn%	Ni%
96.11%	1.81%	0.75%	0.72%	0.16%	0.15%	0.14%	0.12%	0.05%	0.01%


Гэрлийн микроскопоор авсан зураг 5,6




Зураг 5. Чимэглэлийн ард наалдсан бөс даавуу



Зураг 6. Чимэглэлийн ар хэсэгт наалдсан үйсэн эдлэл



Зураг 7. Гэрлийн микроскопын авсан зураг



Зураг 8. Нэхмэлийн техник энгийн ёрог нэхээс

Уйгур, Киргиз, Хятан зэрэг төрт улсын оршуулгын зан үйлд нар, сарны дүрсийг дагуулан тавих зан үйл уламжлагдаагүй нь өнөөг хүртэл малтан судалсан дурсгалуудаас илэрхий байна. Хөвсгөл аймгийн Улаан уул сумын Хориг уулнаас анх удаа илрүүлсэн алт, мөнгөн нар, сарны дүрсүүд, шар тос, өрөмтэй мөнхийн зул зэрэг олдвор баримтууд нь Хүннү, Монголын Эзэнт гүрний удам угсаа, шүтлэг бишрэл, зан үйлийн тасаршгүй гүн бат холбоог бодит баримтаар нотолж байна [Баярсайхан 2021: 9]. Монголын Эзэнт гүрний үед хамаарах Хориг уулын дурсгалаас олдсонтой ижил нар, сарны дүрстэй эд өлгийн зүйлийн тухай өнөөгийн байдлаар хоёрхон мэдээ баримт байна

хэмээн судлаач Ж.Баярсайхан өөрийн бүтээлдээ үзсэн бол энэхүү мэдээг дахин нэгээр нэмэх баримт Буурал уулын 2-р булшнаас илэрсэн нар, сарыг дүрсэлсэн богтаг малгайн дугуй мөнгөн чимэглэл болж байна.

2-р чимэглэл. Хаан төрийн долоон эрдэнэ хэмээх эдгээр эд зүйлсийг дөрвөн их тивийг захирсан Алтан хүрдэгт Загарбардин (*санскритаар Чакравартин*) хаан эзэмшдэг гэж Буддын шашинд үздэг. Энэхүү хаан нь улс гүрнээ амар хялбар саадгүй захирахын тулд урьд үйлдсэн агуу их буяныхаа хүчээр эдгээр эрдэнэсийг эзэмшдэг ажээ. Харин эдгээр эрдэнэсийг бурханд өргөсөн хүн хойд төрөлдөө Загарбардын хаан болж төрөх

эсвэл бурхны номыг үзэх гадаад, дотоод нөхцөл төгс бүрдсэн газар төрөх үйлийн барилдлагатай болдог гэж үзэх тул хаан төрийн долоон эрдэнийг бурханд өргөх явдал Буддын шашинтай орнууд ялангуяа Монголд ихээхэн түгээмэл байжээ. Энэхүү хаан төрийн долоон эрдэнийн нэг нь Чандмань эрдэнэ юм. [Бийр 2022: 49]. Чандмань эрдэнэ нь Номин эрдэнийн өнгөтэй, таван өнгийн гэрэл цацруулан 3000 ертөнцийг гийгүүлдэг. Энэ нь хаанд бүх улсаа харж хянах боломж олгодог төдийгүй гэрэл нь шөнийг өдөр, хүйтэнийг дулаан, халууныг сэрүүн болгож хувиргадаг байна. Түүнчлэн өвчин зовлон, зуурдын үхлээс сэргийлэх, хүслийг биелүүлэх удистай хааны эрдэнэ ажээ [Бийр 2022: 232]. Тэгвэл тус чандмань хэлбэрийн цог чимгийг эзнийгээ өвчин зовлон, зуурдын үхлээс хамгаалах, хүслийг биелүүлэх удистай хэмээн бэлгэдэн малгайн нүүрэн талд чимэглэн хаддаг байжээ.

Дүгнэлт

Бид энэхүү өгүүлэлдээ 1980 онд Дархан уул аймгийн Хонгор сумын нутаг Буурал уулын 2-р булшны малтлага судалгаагаар илэрч олдсон монгол эхнэрийн богтаг малгайн цог чимгийн тухай танилцууллаа. Энэхүү богтаг малгайн цог чимэг нь ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Булш оршуулгын сан хөмрөгийн туслах бүртгэлд БУ-83 дугаартай хадгалагдаж байна.

Уг дурсгалаас илэрсэн богтаг малгайн 1-р чимэглэлд химийн найрлагын анализ хийн алтны хольцтой мөнгөн эдлэл болохыг тогтоосон. Үүний дараагаар гэрлийн микроскопын арга ашиглан чимэглэлийн ар талд хадгалагдан үлдсэн зүйлийн бүтцийг тогтоон органик болон үйсэн эдлэл болохыг тодруулсан. Мөн түүн дээр одон гарагийн тэмдэг буюу нар, сарыг дүрсэлсэн нь Хүннү, Монголын Эзэнт гүрний удам угсаа, шүтлэг бишрэл, зан үйлийн тасаршгүй гүн бат холбоотой байсан гэх баримтыг нэгээр нэмлээ гэж үзэж байна.

Буурал уулын 2-р булшнаас илэрсэн богтаг малгайн 2-р чимэглэлийн үрэгдэж алга болсон хэсгийг зургаар сэргээн Чандмань эрдэнийг бэлгэдсэн чандмань хэлбэрийн зохиомжтой чимэглэл болохыг тодруулсан юм. Мөн тус чимэглэлийн оройн хэсэгт органик гаралтай зүйл болон тана чулууг шигтгэжээ. Гэрлийн микроскоп ашиглан шигтгэсэн органик эдлэлийн нэхээсний бүтцийн төрлийг тодорхойлсон. Энэхүү нэхээс нь энгийн ёрог нэхээс байсан ба магадгүй манай нутагт малтан судалсан булш оршуулгын зарим булшнаас илэрсэн шигтгээгүй олон төрлийн чимэглэлүүдэд ийм төрлийн органик гаралтай эдлэл байсан байх боломжтой нэгэн баримт болох юм.

Бид сан хөмрөгт хадгалагдаж байгаа нэгэн сонирхолтой цог чимгийн тухай мэдээллийг хүргэхийг зорилоо. Мөн судалгаагаа цаашид улам нарийсган үргэлжлүүлэх хүсэлтэй байгаа бөгөөд тухайн бөс даавуу, түүний материал болон нэхмэлийн ширхэгтийг тодорхойлох, яагаад чандмань эрдэнийн орой дээр үнэт чулуу бус бөс даавуун шигтгээг тусгайлан хийсэн учир бэлгэдлийг нэхэн тодруулахыг хичээх болно. Судлаачдын дараа дараагийн судалгаанд ач холбогдолтой эх хэрэглэгдэхүүн болно гэж найдаж байна.

Ном зүй

Амартүвшин нар. 2015 – Амартүвшин Ч., Гүнчинсүрэн Б., Эрэгзэн Г., Бадма-Оюу Б., Өлзийбаяр С., Батсүрэн Б., Базаргүр Б., Амгалантөгс Ц., Лхүндэв Г., Мандах Д., Галдан Г., Батдалай Б., Очир Б., Одмагнай Г. “Эгийн голын түүх, археологийн дурсгалуудын авран хамгаалах судалгаа” төслийн тайлан. УБ, 2015. Тал. 173, 175.

Ангарагсүрэн нар. 2020 – Ангарагсүрэн О., Мөнхцэцэг Б. Эртний эд өлгийн дурсгалт зүйлсийн материалын шинжилгээний ач холбогдлын тухай өгүүлэх нь. Чандмань хар уулын археологийн дурсгал II. УБ, 2020. Тал. 152.

Баярсайхан 2021 - Баярсайхан Ж. Хориг уулын монгол язгууртны булшнаас гарсан нар, сарны алт, мөнгөн дүрсүүд ба Хүннү, Монголчуудын шүтлэг, зан үйлийн залгамж холбоо. – Чингис хаан музейн сэтгүүл. Том. I, Fasc. I-XII, УБ, 2021. Тал. 8,9.

Крамаровский 2019 – Крамаровский М.Г. Золотая орда и причерноморье уроки Чингисидской империи. М, 2019. 44 с.

Бийр 2022 - Бийр Р. Чандмань эрдэнэ. Төвдийн бэлгэдэл. УБ, 2022. Тал. 49, 232.

Наваан 2018 - Наваан Д. Бууралын шинэ олдворууд. Д.Наваан Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, дурсамж. УБ, 2018. Тал. 109. / Эрхэлсэн Д.Заяабаатар/

Томоми Мүраками 2020 - Мүраками Т. Чандмань хар уулын зарим дурсгалаас илэрсэн бөс даавуун эдлэлийн шинжилгээний үр дүнгээс. Чандмань хар уулын археологийн дурсгал II. УБ, 2022. Тал. 116.

Erdenebat 2009 - Erdenebat U. *Altmongolisches Grabbrauchtum. Archäologisch-historische Untersuchungen zu den mongolischen Grabfunden des 11. bis 17. Jahrhunderts in der Mongolei.* Bonn, 2009. Pp. 242.

Эрдэнэбат 2010 - Эрдэнэбат У. Богтаг малгайн чимэглэл (“Монголын нууц товчоон”-ы “цогтой эм” хэмээх үгийн учир). – Оюуны хэлхээ. №1 (06), УБ, 2010. Тал. 14, 15, 18, 32,33.

Эрдэнэбат 2011 - Эрдэнэбат У., Төрбат Ц. Онгон нутгийн өв соёл. – Үзэсгэлэнгийн каталоги, УБ, 2011. Тал. 28.




*Зураг 1. Дугуй мөнгөн чимэглэл.
Дархан уул аймаг Хонгор сум Буурал уул Були-2*



*Зураг 2. Чандмань хэлбэрийн чимэглэл.
Дархан уул аймаг Хонгор сум Буурал уул Були-2*



Зураг 3. Дугуй мөнгөн чимэглэл.
Дархан уул аймаг Хонгор сум Буурал уул Були-2



Зураг 4. Чандмань хэлбэрийн чимэглэл
Дэвшүүлж буй таамаглалдаа үндэслэн сэргээн төсөөлсөн зураг




Зураг 9. Богтаг малгайн чимэглэл. Сүбаатар аймаг Онгон сум. Таван толгойн Були-5. [Эрдэнэбат 2010: 32]



Зураг 10. Богтаг малгайн чимэглэл. Архангай аймаг Хотонт сум, Хулхийн ам Були-8 [Эрдэнэбат 2010: 32]




Зураг 11. Асгат, Шарга уул, Були-2
[Эрдэнэбат 2010: 32]




Зураг 12. БНХАУ, Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Аохань хошуу [Эрдэнэбат 2010: 32]




Зураг 13. БНХАУ, Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Шилийн гол аймаг, Зүүн Үзэмчин хошуу [Эрдэнэбат 2010: 33]




Зураг 14. ОХУ, Бухар орчмын Шахрисябын баянбүрд, Эрмитаж [Эрдэнэбат 2010: 33]



Зураг 15. Богтаг малгайн алтан чимэглэл Алтан орд. XIII – XIV зууны 2 дугаар хагас 1887 онд Ставрополь мужийн Киевское тосгоны ойролцоо Юн-Бабагийн толгодоос санамсаргүй олсон. [Г.М.Крамаровский 2019:144]





Зураг 16. Богтаг малгайн хүрэл чимэглэл Алтан орд. XIV зуун Селитрэнни суурингаас санамсаргүй олсон. [Г.М.Крамаровский 2019:144]



Зураг 17. Богтаг малгайн чимэглэл. Дархан уул аймаг Хонгор сум Буурал уул Були-2 Сэргээн зурсан байдал. (Э.Амарболд)



Зураг 18. Богтаг малгайн оройн чимэглэл. Булган аймаг Хутаг-Өндөр сум Баянголын ам Були-4 Сэргээн зурсан байдал. (Э.Амарболд)



Зураг 19, 20.
XIII зууны хатдын богтаг малгайтай хөрөг зураг